

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Дорнод аймгийн Мал хамгаалах сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/З/СТА-ЗГТС**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: [bolortuulb@audit.gov.mn](mailto:bolortuulb@audit.gov.mn)

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: [semjidmaai@audit.gov.mn](mailto:semjidmaai@audit.gov.mn)

Гэрээт аудитор: З.Шинэхүү

Утас: 7058-4207, Цахим хаяг: [shinekhuz@audit.gov.mn](mailto:shinekhuz@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит



## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	10
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	12
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Залруулсан алдаа.....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	13
Аудитын зөвлөмж.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	10
4. Менежментийн захидал.....	10
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	10



# 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



## ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.25 № 231  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН Г  
ДАРГА Ж.АЛИМАА ТАНАА

### Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Мал хамгаалах сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Мал хамгаалах сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Ковид-19 цар тахалтай холбоотой 2020 онд Мал хамгаалах сангийн хөрөнгийг хөтөлбөр арга хэмжээнд зарцуулаагүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

2021.02.25 №231

D: Mv computer – TOOT A4

011021299



**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	179825919.00	256977530.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	116881654.29	186495202.29
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	116881654.29	186495202.29
3121	Төгрөг	116881654.29	186495202.29
31211	Төрийн сангийн харилцах	116881654.29	186495202.29
33	АВЛАГА	62944264.71	50750327.71
336	Зээлийн авлага	62944264.71	50750327.71
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	62944264.71	50750327.71
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	62944264.71	50750327.71
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	179825919.00	256977530.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	179825919.00	256977530.00
51	Засгийн газрын хувь оролцоо	179825919.00	256977530.00
512	Хуримтлагдсан үр дүн	179825919.00	256977530.00
51210	Өмнөх үеийн үр дүн	179825919.00	179825919.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	179825919.00	256977530.00

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	11,532,555.00	78,591,611.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	11,532,555.00	78,591,611.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	11,532,555.00	78,591,611.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	11,532,555.00	78,591,611.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	9,180,000.00	1,440,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,180,000.00	1,440,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,180,000.00	1,440,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	2,352,555.00	77,151,611.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,352,555.00	77,151,611.00

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	56055337.00	90785547.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	56055337.00	90785547.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	56055337.00	90785547.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	56055337.00	90785547.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	9180000.00	21172000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9180000.00	21172000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9180000.00	21172000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		21172000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	46875337.00	69613547.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	46875337.00	69613547.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	70006317.29	116881654.29
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	116881654.29	186495202.29



## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайл

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	177,473,364.00	0.00	177,473,364.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	177,473,364.00	0.00	177,473,364.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
C07	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	2,352,555.00	0.00	2,352,555.00
C08	2018оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	179,825,919.00	0.00	179,825,919.00
D01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	179,825,919.00	0.00	179,825,919.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	179,825,919.00	0.00	179,825,919.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайланг үеийн үр дүн	0.00	0.00	77,151,611.00	0.00	77,151,611.00
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	256,977,530.00	0.00	256,977,530.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайланг оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,000,000.00	9,180,000.00	156,881,600.00	21,172,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40,000,000.00	9,180,000.00	156,881,600.00	21,172,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,000,000.00	9,180,000.00	156,881,600.00	21,172,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,000,000.00	9,180,000.00	156,881,600.00	21,172,000.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40,000,000.00	9,180,000.00	156,881,600.00	21,172,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	40,000,000.00	9,180,000.00	156,881,600.00	21,172,000.00

2.6 Тус сан нь нэмэлт санхүүжилтийн дансгүй болно.

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Мал хамгаалах сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг Ж.Алимаа танд танилцуулж байна.



Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн программын талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 24-ний хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын гэрээт аудитор З.Шинэхүү хариуцаж хэрэгжүүлэв.

Дорнод аймгийн Мал хамгаалах сан 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 54 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ**

Дорнод аймгийн Мал хамгаалах сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнахтай холбогдсон үйл ажиллагаа юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

### **3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ**

Дорнод аймгийн Мал хамгаалах сан санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүүгийн хяналт аудитын албнаас 2018-2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд 2020 онд хяналт шалгалт хийсэн байна.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 1,440.0 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 28.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### **3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Дорнод аймгийн Мал хамгаалах сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 77,151.6 мянган төгрөгөөр буюу 42.9



хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, мөнгөн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	116,881.6	186,495.2	69,613.6
Авлага	62,944.3	50,750.3	-12,194.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	0.0	19,732.0	19,732.0
Үндсэн хөрөнгө	-	-	-
<b>Нийт хөрөнгө</b>	<b>179,825.9</b>	<b>256,977.5</b>	<b>77,151.6</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	179,825.9	256,977.5	77,151.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>179,825.9</b>	<b>256,977.5</b>	<b>77,151.6</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 186,495.2 мянган төгрөг байна. Энэ нь мал хамгаалах сангийн дансны үлдэгдэл төрийн сантай дансны үлдэгдлийг баталгаажуулсан байна.

Авлага дансны үлдэгдэл 50,750.3 мянган төгрөг болж өмнөх оноос 12,940.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 19,732.0 мянган төгрөг болж хангамжийн материал худалдан авсан байна.

Дорнод аймгийн Мал хамгаалах сангийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 67,059.1 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд үндсэн бус үйл ажиллагааны орлого өмнөх оноос нэмэгдсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 1,440.0 мянган төгрөгөөр буюу 84.3 хувиар буурсан байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 156,881.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 156,881.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### Төсвийн гүйцэтгэл



Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 156,881.6 мянган төгрөгийн төсөв баталсныг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 21,172.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Улсын /орон нутгийн/ төсөвт төвлөрүүлэх орлого**

Улсын /орон нутгийн/ төсөвт орлого төвлөрүүлдэггүй байна.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилт байхгүй байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны талбарт байхгүй, үйл ажиллагаа эхэлснээс хойш шилэн данс нээлгэх хүсэлт явуулж байгаагүй байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 15,384.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Зөрчил арилгах 2 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт

/мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	15,384.7	1	15,384.7	0.0	0.0	0.0
Нийт дүн	1	15,384.7	1	15,384.7	0.0	0.0	0.0

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлжээ.

#### **Залруулсан алдаа**

Санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгийг 1 төгрөг дутуу тайлагнасан тул залруулга хийлээ.



### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 1 албан шаардлага хүргүүлээ.

Үүнд: Шилэн дансны талбарт байхгүй, үйл ажиллагаа эхэлснээс хойш шилэн данс нээлгэх хүсэлт явуулж байгаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 3.1-д "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна", 3.2.3-д "Засгийн газрын тусгай сан" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 1 зөрчилд зөвлөмж өгч менежментийн захидалд тусгав.

### **3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Байхгүй.

## **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Дотоод хяналттай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн программгүй excel программаар бүртгэлийг хийж хөтлөн ажилладаг байна.
- 1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<b>Дорнод аймгийн Мал хамгаалах сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020			ДОА-2021/3/СТА-ЗГТС



A

Шалгагдсан  
байгууллагын нэр:

**Дорнод аймгийн Дорнод аймгийн  
Мал хамгаалах сан**

Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул- лагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны талбарт байхгүй, үйл ажиллагаа эхэлснээс хойш шилэн данс нээлгэх хүсэлт явуулж байгаагүй байна.	0.0	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Ж.Алимаа Б.Золзаяа
2	Санхүүгийн тайлангийн программгүй excel программаар бүртгэлийг хийж хөтлөн ажилладаг байна	0.0	Зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Ж.Алимаа Б.Золзаяа
<b>ДҮН</b>		0.0			